



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Цахим шуудан: [umnu.gov@audit.gov.mn](mailto:umnu.gov@audit.gov.mn)

НОЁН СУМЫН СОНГУУЛИЙН  
ХОРООНД

2025.04.21 № 339  
таний -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2025 оны Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалaa.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2025 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2025 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

“Монгол ардын нам”-ын Ноён сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр ( ... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Ноён сумын Монгол ардын намын хороонд



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
“НОЁН-ШИНЭ СЭРГЭЛТ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Энэхүү мөрийн хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны үзэл баримтлал”, Монгол Ардын Намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, Өмнөговь аймгийн суурь судалгаанууд, иргэдийн саналд тулгуурлан боловсруулав.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь 5 бүлэг, 24 дэд бүлэг, 124 заалтаас бүрдэнэ. Хавсралтад мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг нарийвчлан тодорхойлж, төсвийг тооцсон болно.

**НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1. Хөгжсөн өрх**

- Сумын нийгмийн судалгаанд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажилгүйдлийн бүртгэл судалгаа хийж ажлын байр бий болгоно.
- Өрхийн амьжиргааны түвшин доогуур болон ажилгүй иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулна.
- Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж гарааны бизнес эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- Нийгмийн халамжаас олгодог хүнсний талон олголтод хяналт тавина.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настнуудын нийгмийн хамгааллыг сайжруулж амралт болон сувилалд хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- “Нэг өрх -нэг ажлын байр” төслийг хэрэгжүүлж, ажилгүйдлийг бууруулна.
- Хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг мөрдөх зорилгоор “Сүү тараг” төслийг бодлогоор дэмжинэ.
- Тусгай хэрэгцээ /Хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

**2. Эрүүл Ноёнчууд**

- “Хамгийн чухал нь эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд иргэн бүрийг 2 жилд тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна.
- “Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг үргэлжлүүлж эх нялхсын эрүүл мэндийг хамгаална.
- Сумын эрүүл мэндийн төвд уламжлалт анагаахын кабинет тохижуулахад дэмжих бодлого баримтална.
- “Эрүүл зүрх” аяны арга хэмжээг зохион байгуулж цусны даралт ихсэлтийн эрт илрүүлгийг 80% хүртэл нэмэгдүүлнэ.

13. Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэй технологийг нэвтрүүлж, эх нутагтаа цогц оношуулж, эмчлэгдэх боломж нөхцөлийг бурдуулнэ.
14. Фитнес, иог, нийтийн бүжиг, унадаг дугуйн соёл, явган аялал, зөв хооллолтын клуб зэрэг эрүүл дадал хэвшлийг бий болгох талаар иргэдийг дэмжиж ажиллана.
15. Зориулалтын бус ундны усны савны хэрэглээг халж эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны савтай болгох хөдөлгөөн өрнүүлнэ.
16. Суманд ирж ажиллах эмнэлгийн эмч мэргэжилтнийг тогтвортой суурьшилтай ажиллуулна.
17. Сумын эрүүл мэндийн төв /Сум дундын эмнэлэг/-тэй хамтран охидын жирэмслэлт болон жирэмсний эрт илрүүлэгт хяналт тавьж мэдээ мэдээллээр хангаж ажиллана.

### **3. Боловсролыг эх нутагтаа**

18. Хүүхэд бүрийг боловсролтой болгох зорилгоор анги завсардал гаргахгүй байх тал дээр бодлого барьж ажиллана.
19. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
20. Цэцэрлэгийг түшиглэн хүүхдийн зуны ясли, сувилал ажиллуулна.
21. Сургуулийн өмнөх боловсролын насын хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулна.
22. Сумын сургуулийн дотуур байр, гал зуух, спортын болон урлагийн арга хэмжээнд хэрэгцээтэй байгаа бараа материал нийлүүлэхийг бодлогоор дэмжинэ
23. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, зайн сургалтаар иргэдийн амьдрах ухааны боловсролыг дээшлүүлнэ.
24. Сумын ерөнхий боловсролын сургууль дээр хэрэгжүүлэх угийн бичиг хөтлөх арга хэмжээг дэмжиж ажиллана.
25. “Оюуны хурд-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг сайжруулна.
26. “Хүүхэд хөгжлийн тулхүүр-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхэд залуучуудад эх оронч ухаарал, үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлнэ.
27. Монгол хэл, бичгээрээ зөв ярьж, бичиж сурх чадварыг бий болгох зорилгоор “Хос бичигтэн” төслийг хэрэгжүүлж, үндэсний Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.
28. Хүүхэд залуучуудын гадаад хэлний боловсролыг сайжруулах зорилгоор “Англи хэлтэй Ноён-2” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### **4. Амар амгалан- Аз жаргалтай гэр бүл**

29. Шинээр гэр бүл болж байгаа залуучуудад “Хариуцлагатай эцэг эх бодлогын хүрээнд хүүхдийг дээдэлсэн гэр бүлийг төлөвшүүлнэ”.
30. Сумаас Улаанбаатар хотод суралцаж байгаа оюутнуудын сурх, амьдрах таатай орчин бүрдүүлнэ.
31. “Хариуцлагатай эцэг, эх” бодлогыг хэрэгжүүлж хүүхдийн эрхийг дээдэлсэн гэр бүлийг төлөвшүүлнэ.
32. “Хөгжлийн ирээдүй оюунлаг залуучууд-2” хөтөлбөр хэрэгжүүлж залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжинэ.
33. Суманд “Залуучууд хөгжлийн төв”- ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

### **5. Соёлын өвийг хамгаалах**

34. Суманд Ёслол хүндэтгэлийн өргөөг байгуулах, түүний үйл ажиллагааг тогтмол ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
  35. Музейн ажилтантай хамтран орон нутгийн түүхэн дурсгалт газруудыг бүртгэлжүүлж, Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах. /Ноён ,Сэврэйн хийц/
- 6. Спорт**
36. Нийтийн биеийн тамир үндэсний болон спортын бусад төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор тамирчид мэргэжлийн холбоодыг дэмжиж ажиллана.
  37. Үндэсний спортын төрлүүдээр амжилт гаргасан мэргэжлийн холбоод болон багш, дасгалжуулагч, тамирчдыг бодлогоор дэмжиж ажиллана.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### **1. Хариуцлагатай төсөв- тогтвортой хөгжил**

38. Төсвийн хөрөнгийн үр ашигтай хэмнэлттэй хариуцлагатай бодлогыг хэрэгжүүлж төсвийн гүйцэтгэлд иргэд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлнэ.
39. Төсөв санхүүгийн хувьд орон нутгийн биеэ даасан тогтвортой байдлыг нэмэгдүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.
40. Орон нутгийн үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлэх төсөл хөтөлбөрт хамруулна.
41. Тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ шинээр байгуулах

### **2. Мал аж ахуй**

42. Чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлж малчдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийг хөнгөвчлөх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх.
43. Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч, халдварт өвчингүй тайван бус нутгаа баталгаажуулна.
44. Малын үүлдэр угсааг баталгаажуулж, таваарлаг чанарыг нэмэгдүүлэх, мал, малын түүхий эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
45. Сумын мал эмнэлэг ХАА-н тасагтай хамтран мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээ авч малын халдварт өвчинтэй тэмцэнэ.
46. Эрүүл мал “Жишиг өвөлжөө хаваржаа” аяны хүрээнд нийт малчин өрхийн малыг ариутгалд хамруулна.
47. Бэлчээрийн даацыг тэнцвэржүүлж, усан хангамжийг нэмэгдүүлэх, усны хомсдолтой бэлчээрт гүн өрмийн худаг гаргах
48. Малын үүлдэр угсааг сайжруулж таваарлаг цөөн тооны малыг өсгөн үржүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
49. Сум дундын отрын бус нутгийг шинэчлэн тогтоох замаар нөөц бэлчээрийг бий болгоно.

### **3. Эрүүл аюулгүй хүнс**

50. Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр тогтвортой хангах, хүнсний ногоо дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутагт газар тариалан эрхлэх ААНБ, иргэдийг дэмжин тариалангийн талбайг нэмэгдүүлнэ.

51. "Хүнсний ногоо" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн газар тариалан эрхлэгчдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, шинэ, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, туршилт судалгааны ажлыг үргэлжлүүлэн нэгжийн ургацыг нэмэгдүүлж, орон нутгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг бүрэн хангана.
52. Өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой хүлэмжтэй өрхийн тоог нэмэгдүүлнэ.
53. Өмнөговь аймгийн ХАА-н газартай хамтран хүлэмжийг аж ахуйг дэмжиж, орон нутагт өвлийн хүлэмж байгуулна.

#### **4. Өрхийн үйлдвэрлэл**

54. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж төсөл хөтөлбөрт хамруулна.
55. Орон нутгийн өмчит тохижилт үйлчилгээний ААНБ шинээр байгуулж, Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зорилготой иргэд, ААН-ийг бодлогоор дэмжинэ
56. Малын тэжээлийн ургамал тариалах болон жижиг бэлчээр хаших ажлыг дэмжиж ажиллана.
57. Ноён сумын төвд төр хувийн хэвшилтэй хамтарсан эсгийний үйлдвэр барьж ашиглалтад оруулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
58. Тэмээчдийн ашиг орлогыг нэмэгдүүлж хоёр бөхт монгол тэмээний үнэлэмжийг нэмэгдүүлнэ.
59. Малын суу, цагаан идээний брэнд бүтээгдэхүүн бий болгоно.
60. Уламжлалт аргаар арьс нэхийгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх цехийн үйл ажиллагааг бий болгож тохижуулна.
61. Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, "Үйлдвэрлэгч-өрх" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### **5. Эрчим хүч, дэд бүтцийн чиглэлээр**

62. Даланзадгад-Гурвантэс чиглэлийн автозамд холбогдох хатуу хучилттай автозам барих зураг төсөв боловсруулах, ажлыг эхлүүлэх.
63. 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж ашиглалтад оруулахад хяналт тавьж ажиллана.
64. Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, байр хорооллыг бүрэн гэрэлтүүлэгт холбо.
65. Сумын төв доторх хатуу хучилттай автозам, явган болон дугуйн замыг нэмэгдүүлэх.
66. Сумруу ордог, гардаг хэсгийн даваануудыг засаж янзлах, угтах үдэх хэсгүүдийг тохижуулах

#### **6. Орон сууц**

67. Орлогод нийцсэн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
68. Орон сууцжуулах ажлын хүрээнд барилга үйлдвэрлэлийн цэгтэй болно.
69. Эко хороопол бий болгох
70. Төрийн өмчит байгууллагуудын орон сууцуудыг инженерийн шугам сүлжээнд бүрэн холбох

#### **7.Мэдээллийн технологи, харилцаа холбоо**

71. Харилцаа холбоо, мэдээллийн технологийг орон нутагт шинээр нэвтрүүлэхэд дэд бүтцийг байгуулах, өргөтгөх ажлыг төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, цахимжуулах ажилтай уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

72. Сумын хүүхэд залуучууд, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн талбайд болон дугуйн замын дагуу цахим сүлжээний WiFi орчин бий болгож, ТҮЦ машинтай болох арга замыг судалж бий болгох

## ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

### 1.Ухаалаг Ноён- Шуурхай үйлчилгээ

73. Эмнэлгийн үзлэгийн цаг, шинжилгээний хариу, бүтээн байгуулалт, хэрэглэгчийн үнэлгээ, лавлагаа, хуулбар, өргөдөл гомдол, ажлын байрны мэдээлэл зэрэг төрийн байгууллагын үйлчилгээг нэгтгэн “Ухаалаг Ноёнчууд” цахим системийг нэвтрүүлнэ.
74. Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангаж, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлэн “Надад санал байна” цахим хуудсыг ажиллуулна.
75. Иргэн төрийн байгууллагад хандан өргөдөл хүсэлт гаргах, шийдвэрлэлтийн явцыг хянах, хариугаа авах ажиллагааг бүрэн цахимжуулж “Миний өргөдөл” гар утасны аплекейшнийг бий болгоно.
76. “Олон нийттэй харилцах алба 98181155”-ийн үйл ажиллагааг өргөтгөн “Мэдээллийн төв” болгоно.
77. “Хөдөлгөөнт баг”, “Явуулын оффис”-оор дамжуулан сум, баг, застав, иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэнэ.
78. Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлт, дуудлагыг хүлээн авах “Мессеж” үйлчилгээг төрийн байгууллагад шинээр нэвтрүүлнэ.
79. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, цогц үйлчилгээтэй болгоно.
80. Иргэдийн цахим үйлчилгээ авах, мэдээллийн технологи ашиглах мэдлэг, ур чадварыг сайжруулах “Цагаа хэмнэж, цахимаар үйлчлүүлье” аяныг өрнүүлнэ.
81. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг фейсбуук лайв /live/, орон нутгийн телевизээр шууд нэвтрүүлж сонгосон төлөөлөгчийнхөө оролцоог хянадаг болно.
82. Патент, тусгай зөвшөөрөл, газар олголтын шийдвэрлэлтийн үйл явцыг шилэн болгоно.
83. Газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.
84. “Ухаалаг бүртгэл” төслийг хэрэгжүүлэн улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай авах аплекейшнийг бий болгож иргэдийн хэрэглээнд нэвтрүүлнэ.
85. Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг иргэдийн хяналтад тулгуурлан сайжруулах бодлого хэрэгжүүлж, нийтийн удирдлагын ил тод байдлыг хангана.
86. Үйлчилгээний шуурхай, цэгтэй байдлыг хангасан төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг бэлтгэн гаргах “Стандарттай Ноёнчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
87. Тусгай хэрэгцээ /Хөгжлийн бэрхшээл/-тэй иргэд төрийн бүх байгууллагад чөлөөтэй нэвтрэх, үйлчилгээг саадгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.

## **2. Бүтээмжтэй, мэргэшсэн төрийн албан хаагч**

- 87 Төрийн бүх байгууллагад угтах үйлчилгээг нэвтрүүлж үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.
- 88 Ахисан түвшний болон мэргэжил дээшлүүлэх сургалтад 10-с доошгүй төрийн албан хаагчийг хамруулна.
- 89 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, тогтвортсуурьшилтай ажиллуулах “Амжилтад тулгуурласан амьдралын баталгаа” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 90 Орон нутагт дутагдалтай байгаа зах зээлд хэрэгцээтэй мэргэжил эзэмшүүлэхэд политехникийн коллеж болон их, дээд сургуулиудтай хамтарч ажиллах бодлого хэрэгжүүлнэ.
- 91 Хөдөө орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдад зориулсан өмчлөх эрхтэй түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 92 Төрийн албан хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр явуулах болсонтой холбогдуулан Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн боловсролыг сайжруулна.

## **3. Тохилог баг-Тогтвортой үйлчилгээ**

- 93 “Тохилог баг-тогтвортой үйлчилгээ”-г хэрэгжүүлнэ.
- 94 Бүтээн байгуулалт, олон нийтийн ажилд иргэдийн оролцоог хангах зорилгоор багуудыг “Аравтын систем”, хөршийн холбоодоор зохион байгуулж ая тухтай, амар амгалан орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 95 Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.

## **4. Аюулгүй -Амгалан сум**

- 96 “Алган дээрх Ноён” хөтөлбөрийн хүрээнд сумын төв, гэр хорооллыг камержуулж иргэдийн аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаална.
- 97 Сумын хэмжээнд архинаас татгалзах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж “Архигүй-амар амгалан гэр бүл”-ийг бий болгоно.
- 98 Аз жаргалтай хүүхэд нас” төслийн хүрээнд цахим тоглоомын донтолтоос урьдчилан сэргийлж, цахим гэмт хэргээс хамгаална.
- 99 “Эрх зүйн мэдлэгийг иргэн бүрд” хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн эрхээ хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ.

## **5.Хөгжилд хөтөлсөн гадаад харилцаа**

- 100 Хөрш зэргэлдээ болон гуравдагч орнуудтай эдийн засгийн харилцан ашигтай, орон нутгийн хөгжлийг дэмжсэн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 101 Иргэд, төрийн албан хаагчдыг гадаад оронд сургаж, мэргэшүүлэх “Зөгийн үүр-2” хөтөлбөрт мэргэжилтнээ хамруулж хөгжлөөр тэргүүлэгч орны шинэ мэдлэг, технологийг нэвтрүүлэх хөгжлийн гүүр болгон хэрэгжүүлнэ.

## **6. Чадварлаг, зөвлөгч хууль сахиулагч**

- 102 Иргэдэд зөвлөх замаар хууль дүрмийг мөрдүүлдэг ёс зүйтэй, хууль сахиулагчийг төлөвшүүлж иргэдтэй харилцах хандлагыг сайжруулна

- 103 Сумын нутаг дэвсгэрт байрлах Хилийн цэрэг болон Зэвсэгт хүчний анги байгууллага, бие бүрэлдэхүүний ажиллах орчин нөхцөлд бодлого хэрэгжүүлнэ.
- 104 Цагдаа, эмнэлэг, онцгой байдлын бүрэлдэхүүн бүхий тусlamж үйлчилгээг цогцоор хүргэх “Мэдээлэл, шуурхай удирдлагын төв” байгуулна.

## ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.Хариуцлагатай уул уурхай

- 105 Шинээр хайгуулын болон ашиглалтын лиценз олголтод орон нутгийн иргэдийн хяналтыг сайжруулж, оролцоог нэмэгдүүлнэ.
- 106 Орон нутгийн иргэдэд үр өгөөжгүй, байгаль орчинд хохиролтой уул уурхайн компаниудын ашиглалтын лицензийг цуцлуулж, хохирлыг бүрэн барагдуулна.

### 2.Байгаль орчин- Ногоон хөгжил

- 107 Сумын хэмжээнд жил бүр 500 модыг тарьж, арчлан хамгаална.
- 108 Байгаль орчны нөхөрлөл, иргэдийн оролцоотойгоор ан амьтан, ус, хөрс, ургамлыг хамгаалж, байгаль орчны нөхөн сэргээлтийг хэрэгжүүлнэ.
- 109 Сумдын төвд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай байгуулах ажлыг үргэлжлүүлж, 10 га-аар нэмэгдүүлнэ.
- 110 Орчны, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Эко жорлон” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 111 Сумын хэрэглэгчдийн усан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, булаг шандны эхийг хашиж хамгаалах, ойжуулах, тохижуулах ажлыг хийх / Уртын гол, Цоохондой, сумын хойт гол гэх мэт/

### 3.Эко-Аялал жуулчлал

- 112 Хөрш зэргэлдээ орны жуулчдын аяллыг хил дамнасан аяллаар өргөжүүлж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 113 Аялал жуулчлалын базын үйл ажиллагааг өргөтгөх, эрчимжүүлэх, ахмадын амралт сувиллын газар байгуулна.

### 4.Эко орчинтой- Орон сууц

- 114 Бага, дунд орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн “Орлогод нийцсэн орон сууц” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 115 Төр, орон нутаг, хувийн хэвшлийн оролцоотой “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 116 Хот, сум, суурины хөгжлийн төлөвлөлтийн дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцыг үе шаттайгаар нэмэгдүүлж, халаалт, цахилгааны эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангах дэвшилтэй технологийг нэвтрүүлнэ.
- 117 Багш нарын орон сууцны байршилд иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

- 118 Сумын гэр хорооллуудын өнгө үзэмжийг сайжруулж, жишиг хорооллуудыг бий болгоно.
- 119 Орон сууцжуулах ажлын хүрээнд барилгын үйлдвэрлэлийн цэгтэй болно.

## ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### 1.Хөгжсөн - Хот байгуулалт

- 120 Гэр хорооллын өрхийн газрыг дахин зохион байгуулж, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайг байгуулах, орчны бохирдлыг бууруулах “Хашаандаа сайхан амьдаръя” төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 121 Газрын нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан иргэнд шинээр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх үйл ажиллагааг нээлттэй ил тод байдлаар шийдвэрлэнэ.
- 122 Хот байгуулалт, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үйл ажиллагааг газрын харилцааны бодлого төлөвлөлттэй уялдуулан оновчтой хэрэгжүүлнэ.
- 123 Иргэд, хувийн хэвшлийн оролцостойгоор барилгын материалын үйлдвэр байгуулж, импортыг орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.

НОЁН СУМЫН НАМЫН ХОРОО



6177144456  
+976 90068 9047824